



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 онь 03 сарын 14 өдөр

Дугаар А/138

Хэрлэн сум

Сургалтын үйл ажиллагаанд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” арвантавдугаар хуралдааны №06 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сурагчдын суралцах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх ширээ, сандлын зардалд зориулан 22,500,000 (хорин хоёр сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шаардлагатай сургууль, цэцэрлэгийг тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 14-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардал	Мөнгөн дүн
1	Ажил эхлэх	18,000,000
2	Ажил дуусах	4,500,000
	нийт	22,500,000